Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,107,137.7	931,724.7	(175,413.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,107,175.7</b>	<b>1,042,347.1</b>	<b>(64,828.6)</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данснууд байна.

Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 103,868.6 мянган төгрөг болсон нь тайлант онд улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгийг харьяа төсвийн ерөнхийлөн захирагчтай тооцоо нийлж баталгаажуулан байгууллагаас авах авлагаар бүртгэсэнтэй холбоотой;

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 316,411.8 мянган төгрөг болж 31,446.7 мянган төгрөгөөр буурсан харилцагчид олгосон гэрээт ажлын урьдчилж гарсан зардлыг анхан шатны баримтыг үндэслэн зардлаар бүртгэсэнтэй холбоотой;

Бараа материал дансны үлдэгдэл 98,240.9 мянган төгрөг болж 5,225.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 32,616.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 37,841.5 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой;

Улсын хүүхэлдэйн театрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 523,825.8 мянган төгрөг болж, 132,025.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас үнэ төлбөргүй өгсөн 3,120.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, өөрийн хөрөнгөөр 82,400.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 6,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн авч, тайлант онд 223,545.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцсоноос шалтгаалсан;

Өглөг дансны үлдэгдэл 110,622.4 мянган төгрөг болж өссөн нь үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг улсын төсөвт татан төвлөрүүлэн зарцуулах эрх олгоогүйн улмаас тендерээр шалгаран тоног төхөөрөмжөө нийлүүлсэн харилцагч байгууллагад төлөх 79,500.0 мянган төгрөг, аудитын болон нислэгийн тийзний төлбөр 16,000.0 мянган төгрөг, ХХОАТ-ын 15,093.5 мянган төгрөг, хувь хүмүүст өгөх 28.9 мянган төгрөгийн өглөгүүд төлөөгүйтэй холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 931,724.7 мянган төгрөг болж 173,415.0 мянган төгрөгөөр буурсан байгаа нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа санхүүгийн, тасалбар худалдаадах зэрэг нийт 6,387.0 мянган төгрөгийн өртөгтэй 4 программуудыг ашиглаж байгаа бөгөөд 3,725.7 мянган төгрөгийн хорогдуулга байгуулан санхүүгийн тайланд тусгасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын хүүхэлдэйг театрын 2025 оны төсвийн төсөлд улсын төсвийн санхүүжилтээр 1,873,118.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, нийт зарлагыг санхүүжүүлэхээр тоохон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 258,833.1 мянган төгрөгөөр бууруулж, 1,621,285.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2025 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан боловч дээд шатны байгууллагаас төсвийг шаардлагатай хэмжээнд баталж өгөөгүйгээс шалтгаалсан байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын дүн, нэр төрөл, зарлагын дүн, нэр төрлөөр төсвийн төслийн боловсруулаагүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,621,285.0 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр төлөвлөсөн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,464,050.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогод 229,348.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,424,050.3 мянган төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 6,795.3 мянган төгрөг, тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлын төсвийг 3,819.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, 40,000.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Соёл урлаг	1,621,285.0	1,424,050.3	197,234.7	87.8

Улсын хүүхэлдэйн театрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

80101	Үндсэн үйл ажиллагаа	1,308,999.5	1,302,204.2	6,795.3	99.4
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	45,685.9	41,866.2	3,819.7	91.5
81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	266,599.6	79,979.9	186,619.7	30.0

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

**Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:** Эрх бүхий дээд байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу 1 менежер, 2 жүжигчин, 1 жижүүр зэрэг 4 ажлын байрыг цомхотгосон байна.

**Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын судалгааны талаар:** Тайлант онд бүтэц орон тоог 37 хүнээр төлөвлөн хоол, унааны хөнгөлөлтөд 183,566.4 мянган төгрөгийг баталсан, гүйцэтгэлээр 37 бүтэц орон тоонд 164,519.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Улсын хүүхэлдэйг театр нь тайлант онд хоол, унааны хөнгөлөлтөд 1 өдрийн 20,000.0 төгрөгийг ажилчдад олгосон, захирлын тушаалаар баталгаажуулаагүй байна.

**Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны талаар:** Тайлант онд гадаад албан томилолт, арга хэмжээнд 23,924.2 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь УХТ-ын төлөөлөгчид 2025 оны 5 дугаар сард БНСУ-д зохион байгуулагдсан Олон улсын хэмжээнд жил бүр зохион байгуулагддаг олон улсын хүүхэлдэйн уран бүтээлийн наадам, ЭШХ-д оролцон, БНСУ-ын жүжигчид болон тус театрын жүжигчидтэй хамтран " Ааруулыг амтлах мөчид" хүүхэлдэйн жүжгийг амжилттай тоглож, олны хүртээл болгон, Монгол улсын хүүхэлдэйн театрын уран бүтээлийг гадаад улсад сурталчилсан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын дэргэдэх олон улсын хүүхэлдэйчдийн холбоонд элсэх ажлын эхлэлийг тавьсан үр дүнтэй арга хэмжээ болсон байна.

**Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны талаар:** Тайлант онд гадаад харилцагчтай 3 удаагийн цахим сургалт хийсэн бөгөөд орчуулагчийн зардалд 1,640.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

**Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны талаар:** Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаагүй, зардал гараагүй байна.

**Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын судалгааны талаар:** Тайлант онд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн дагуу төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 229,348.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Улсын хүүхэлдэйн театрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үүнээс хангамж бараа материалын зардалд 25,365.8 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 4,825.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 80,295.7 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 61,800.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 57,061.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд Соёлын салбарт хэрэгжиж байгаа 1 төсөл хөтөлбөрт оролцон, 1 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	"Go Mongolia" хөтөлбөр	2025-2028	"Өвлийн Нүүдэлчин" Мазаалай Олон улсын цас, мөсний наадам-1 удаа оролцоно. Жилийн эцэст: "Go Mongolia" хөтөлбөрийн хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд-1 Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль-1 удаа оролцоно.	"Өвлийн Нүүдэлчин" Мазаалай Олон улсын цас, мөсний наадамд "Жигүүхэндээ хүчтэй" хүүхэлдэйн жүжгийг 9 уран бүтээлчид бага тайзнаа хүүхэд багачууд болон үзэгчдэд зориулан тоглосон. "Нүүдэлчин" дэлхийн соёлын өвийн фестивальд "Хүүхдийн өртөө"-ний үйл ажиллагааг хариуцан, нийт 12 удаагийн тоглолт ("Жигүүрхэндээ хүчтэй", БНСУ-ын уран бүтээлчидтэй хамтарсан "Ааруулыг амтлах мөчид" хүүхэлдэйн жүжиг), хайрцагт хүүхэлдэйн жүжгийг 6 удаа тус тус тоглосон	19,000.0	18,560.0
2	Дүн				19,000.0	18,560.0

**3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд 387,280.3 мянган төгрөгийн 28 бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлээр 278,480.3 мянган төгрөгийн бараа болон засварын ажлыг шууд худалдан авч, 99,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын хүүхэлдэйг театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бараа материалын анхан шатны баримтын бүрдлийг хангах, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн заалтын дагуу иж бүрэн гаргахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-наас 2025 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Эс Жи Эм Ди-Аудит ХХК-ийн ахлах аудитор О.Алтанцэцэг, аудитын шинжээч Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Оюунцэцэг, захирал Д.Насанжаргал нар, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүү аудитын газрын аудитор Т.Нямсүрэн, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын хүүхэлдэйг театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,612,424.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,124.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь тэтгэвэрт гарсан ажилчдад олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг бусад тэтгэмжтэй давхардуулан олгоогүй, байгууллагын хөрөнгөөр гар утасны төлбөр төлөөгүй, хэвлэл захиалаагүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 306,095.9 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт 1: Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,248,320.2 мянган төгрөгийн 15 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, орлогын 12,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 294,095.9 мянган төгрөгийн 15 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1-т "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсан мэдээлэл байршуулдаггүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 365,811.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 4,100.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 9,431.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснийг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Улсын хүүхэлдэйн театрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,100.0	1	4,100.0	100.0
Албан шаардлага	2	9,431.7	2	9,431.7	100.0
Зөвлөмж	2	0.0	2	0.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>13,531.7</b>	<b>5</b>	<b>13,531.7</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамж нь Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу тайлан мэдээллийг илэрхийлж байгаа эсэхийг үзэх.

Урьдчилж гарсан зардал дансанд тайлагнасан 316,411.8 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл, бүртгэл хөтлөлтийг хянан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,726.1 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрсэнд аудитын явцад 26,726.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Эрх бүхий байгууллагын шийдвэрээр балансаас баланст шилжүүлэн авсан 6,000.0 мянган төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгслийг санхүүгийн үр дүнгийн тайланд өмч хувьчлалын орлого дансанд бүртгэсэн нь УСННБОУС 1, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- БНХАУ-д 11 дүгээр сард зохион байгуулагдсан "Торгоны замын уламжлал театр, урлагийн олон улсын арга хэмжээ"-нд оролцсон зардал 20,726.1 мянган төгрөгийг зохион байгуулагч талаас олгосныг Сангийн яам татан төвлөрүүлсэн, санхүүгийн байдлын тайланд байгууллагаас авах авлагаар тайлагнаагүй нь УСНББОУС 1, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй;

Аудитаар нийт 3,548.5 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 3,140.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 408.0 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,548.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

#### 5.1.1 Бараа материалын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт* 1. Шаардлагагүйгээр их хэмжээгээр удаан хугацаагаар нөөцөлсөн 3,140.5 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалын үлдэгдэл байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шаардлагагүйгээр бараа материалыг их хэмжээгээр нөөцлөхгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, зөрчлийн арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 5.2.1. Төсвийн гүйцэтгэлийн тайлагналтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тайлант жилд 1,464,040.8 мянган төгрөгийн орлого болон зарлагын дүнтэй төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэсэн боловч нийт дүнгээр, хөтөлбөрөөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга зэргийг иж бүрэн тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-т "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.1-т "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/", 54.5.2-т "татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт", 54.5.3-т "тухайн жил худалдан

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл", 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/", 54.5.5-т "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүний дагуу гаргаж байх.

**5.2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн суутгал, хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Хувь хүнд ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон 1,500.0 мянган төгрөг, нийгмийн даатгалд дутуу тайлагнасан 200.0 мянган төгрөг нийт 1,700.0 мянган төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хувь хүнд гэрээгээр олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл суутган тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		/мянган төгрөгөөр/	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрх бүхий байгууллагын шийдвэрээр балансаас баланст шилжүүлэн авсан 6,000.0 мянган төгрөгийн өртөгтэй тээврийн хэрэгслийг санхүүгийн үр дүнгийн тайланд өмч хувьчлалын орлого дансанд бүртгэсэн.	1	6,000.0	-	-	1	6,000.0	1	6,000.0	-	-
2	БНХАУ-д 11 дүгээр сард зохион байгуулагдсан "Торгоны замын уламжлал театр, урлагийн олон улсын арга хэмжээ"-нд оролцсон зардал 20,726.1 мянган төгрөгийг зохион байгуулагч талаас олгосныг Сангийн яам татан төвлөрүүлсэн, санхүүгийн байдлын тайланд байгууллагаас авах авлагаар тайлагнаагүй.	1	20,726.1	1	20,726.1	-	-	1	20,726.1	-	-
	Дүн	2	26,726.1	1	20,726.1	1	6,000.0	2	26,726.1	-	-

Улсын хүүхэлдэйн театрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс				Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо		Дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
1	Шаардлагагүйгээр их хэмжээгээр удаан хугацаагаар нөөцөлсөн 3,140.5 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалын үлдэгдэл байна.	1	3,140.5	-	-	1	3,140.5	-	-	-	-	-	-
2	Хувь хүнд ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон 1,500.0 мянган төгрөг, нийгмийн даатгалд дутуу тайлагнасан 200.0 мянган төгрөг нийт 1,700.0 мянган төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй.	1	408.0	-	-	-	-	-	1	408.0	-	-	-
3	Тайлант жилд 1,464,040.8 мянган төгрөгийн орлого болон зарлагын дүнтэй төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэсэн боловч нийт дүнгээр, хөтөлбөрөөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга зэргийг иж бүрэн тайлагнаагүй.	1	0.0	-	-	-	-	-	1	0.0	-	-	-
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,548.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>3,140.5</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>408.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
	<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>							
1	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,248,320.2 мянган төгрөгийн 15 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, орлогын 12,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 294,095.9 мянган төгрөгийн 15 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	1	306,096.0	1	306,096.0	-	-	-
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>306,096.0</b>	<b>1</b>	<b>306,096.0</b>			
	<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>							
	-	-	-	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-
	<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>306,096.0</b>	<b>1</b>	<b>306,096.0</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 434/20150122

Улаанбаатар хот

САГ-2026/240/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хүүхэлдэйн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэрэгцээ шаардлагагүй их хэмжээгээр нөөцөлж, удаан хадгалсан 3,140,492.92 (Гурван сая нэг зуун дөчин мянга дөрвөн зуун ерэн хоёр төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн үнэ бүхий бараа материалын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн хориглосон заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шаардлагагүй бараа материалыг үндэслэлгүйгээр их хэмжээгээр бэлтгэн нөөцөлдөг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хүүхэлдэйн театрын захирал (З.Баянзул), ерөнхий нягтлан бодогч (Н.Ургамал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.НАСАНЖАРГАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 435/А0150122

Улаанбаатар хот

СЯГ-2026/040/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хүүхэлдэйн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,248,320,200.00 (Нэг тэрбум хоёр зуун дөчин найман сая гурван зуун хорин мянга хоёр зуу) төгрөгийн 15 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, орлогын 12,000,000.00 (Арван хоёр сая) төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 294,095,957.69 (Хоёр зуун ерэн дөрвөн сая ерэн таван мянга есөн зуун тавин долоон мянга жаран есөн) төгрөгийн 13 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хүүхэлдэйн театрын захирал (З.Баянзул), ерөнхий нягтлан бодогч (Н.Ургамал) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

И.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.НАСАНЖАРГАЛ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z. Alban Shaardlaga\2026\0125\SAG-75.Docx

1526180937